СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/81/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Нарантуяа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: Г.Даваа<br>Утас: 70512123<br>Аудитор: О.Барчидгүнсэн<br>Утас: 70512123 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

***1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ*** ........ 3
***2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ*** ........ 5
***3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА*** ........ 11
*3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа* ........ 11
*3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин* ........ 11
*3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал* ........ 11
*3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд* ........ 11
*3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв* ........ 12
***4. АУДИТЫН ТАЙЛАН*** ........ 13
***4.1 Ерөнхий зүйл*** ........ 13
***4.2 Материаллаг байдал*** ........ 14
***4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт*** ........ 14
***4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал*** ........ 14
***4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт*** ........ 14
***4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт*** ........ 15
***4.5.1 Завсрын аудитын талаар*** ........ 15
***5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ*** ........ 15
***5.1 Албан шаардлага*** ........ 15
***6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ*** ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 53

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Н.УЛААНХҮҮХЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоож, үр дүн, гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэнд төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн 164,502.9 мянган төгрөг зарцуулагдаагүй, харилцах дансанд үлдэгдлээр үлдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 87.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **217,101,702.55** | **264,478,176.36** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 38,624,126.27 | 164,502,999.71 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 38,624,126.27 | 164,502,999.71 |
| **3121** | **Төгрөг** | 38,624,126.27 | 164,502,999.71 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 12,215,705.39 | 164,502,999.71 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 26,408,420.88 | - |
| **33** | **АВЛАГА** | 117,736,000.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 117,736,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 60,741,576.28 | 99,975,176.65 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,310,507.75 | 61,929,289.55 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 10,549,664.78 | 45,259,857.78 |
| 35130 | Эм боох материал | 3,760,842.97 | 16,669,431.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 41,421,068.53 | 33,445,887.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,861,840.00 | 3,411,712.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,481,434.00 | 8,823,164.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,606,700.00 | 3,614,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 539,648.45 | 1,952,940.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 20,367,000.60 | 8,897,630.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,545,495.48 | 1,728,210.10 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,018,950.00 | 5,018,031.00 |
| 35600 | Мал амьтад | 5,010,000.00 | 4,600,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **361,940,816.74** | **403,232,767.21** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 361,940,816.74 | 403,232,767.21 |
| **392** | **Биет хөрөнгө** | 353,912,816.74 | 393,209,767.21 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 298,954,935.65 | 298,954,935.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (56,110,299.34) | (62,374,536.46) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31,736,434.00 | 51,736,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,740,956.10) | (27,947,028.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135,670,459.82 | 142,575,282.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (58,171,689.65) | (62,583,329.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,952,874.01 | 62,275,679.01 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,478,941.85) | (18,687,669.66) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,550,000.00 | 16,550,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,449,999.80) | (7,289,999.80) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,028,000.00 | 10,023,000.00 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 2,765,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (770,000.00) | (770,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,028,000.00 | 8,028,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **579,042,519.29** | **667,710,943.57** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **579,042,519.29** | **667,710,943.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 579,042,519.29 | 667,710,943.57 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 285,892,103.87 | 285,892,103.87 |
| 51101 | Өмч: - төрийн | 285,892,103.87 | 285,892,103.87 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 137,405,851.23 | 226,074,275.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 137,405,851.23 | 137,405,851.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 88,668,424.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 155,744,564.19 | 155,744,564.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **579,042,519.29** | **667,710,943.57** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **743,085,446.00** | **519,470,221.90** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **743,085,446.00** | **519,470,221.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 361,338,000.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 361,338,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 234,177,124.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,463,324.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 207,713,800.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 25,810,761.90 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 25,810,761.90 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 17,370,300.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 17,370,300.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 130,200,022.00 | 493,659,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 130,200,022.00 | 493,659,460.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **593,003,560.04** | **486,882,663.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **593,003,560.04** | **486,882,663.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 562,420,246.86 | 484,740,524.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,402,245.41 | 285,170,103.57 |
| 210101 | Үндсэн цалин | 227,048,962.56 | 194,747,797.73 |
| 210102 | Нэмэгдэл | 73,961,780.62 | 64,513,362.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,543,000.00 |
| 210104 | Урамшуулал | 30,391,502.23 | 22,365,943.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,004,681.32 | 38,361,260.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,366,990.35 | 26,882,273.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,713,930.98 | 2,869,746.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,171,144.95 | 2,295,797.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 522,964.99 | 573,950.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,229,650.05 | 5,739,493.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,038,096.37 | 17,437,970.35 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,233,856.92 | 3,407,774.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,804,239.45 | 13,150,196.35 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 880,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 73,363,130.00 | 46,633,559.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,330,545.00 | 6,407,060.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,860,400.00 | 11,980,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,083,170.00 | 1,648,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,871,679.00 | 25,727,899.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,487,336.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,730,000.00 | 870,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 81,570,859.06 | 53,797,477.58 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 68,698,666.00 | 44,760,767.20 |
| 210502 | Хоол, хүнс | 10,735,693.06 | 8,236,710.38 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,136,500.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,569,050.00 | 6,568,647.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,640,150.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,928,900.00 | 6,568,647.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 92,000.00 | 435,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 92,000.00 | 435,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,960,550.00 | 5,468,408.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,960,550.00 | 5,468,408.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,419,634.70 | 30,867,197.16 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 785,750.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,633,884.70 | 30,867,197.16 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 30,583,313.18 | 2,142,139.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,524,350.00 | 2,142,139.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,524,350.00 | 2,142,139.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,058,963.18 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,058,963.18 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **150,081,885.96** | **32,587,558.65** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **150,081,885.96** | **32,587,558.65** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **625,799,446.00** | **637,206,221.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **450,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 450,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 450,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 450,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **625,349,446.00** | **637,206,221.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 361,338,000.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 361,338,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 234,177,124.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,463,324.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 207,713,800.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 25,810,761.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 25,810,761.90 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 17,370,300.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 17,370,300.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 12,464,022.00 | 611,395,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 12,464,022.00 | 611,395,460.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **550,716,819.73** | **462,669,358.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **550,716,819.73** | **462,669,358.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **520,158,506.55** | **460,347,219.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,402,245.41 | 285,170,103.57 |
| 210101 | Үндсэн цалин | 227,048,962.56 | 194,747,797.73 |
| 210102 | Нэмэгдэл | 73,961,780.62 | 64,513,362.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,543,000.00 |
| 210104 | Урамшуулал | 30,391,502.23 | 22,365,943.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,004,681.32 | 38,361,260.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,366,990.35 | 26,882,273.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,713,930.98 | 2,869,746.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,171,144.95 | 2,295,797.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 522,964.99 | 573,950.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,229,650.05 | 5,739,493.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,311,336.82 | 18,898,761.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,233,856.92 | 3,407,774.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,077,479.90 | 14,511,737.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 979,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,211,320.00 | 31,487,927.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,845,420.00 | 4,559,182.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,860,400.00 | 11,933,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,083,170.00 | 1,648,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 29,199,830.00 | 12,899,645.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 222,500.00 | 448,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,827,123.00 | 64,147,808.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,026,458.00 | 55,928,383.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,800,665.00 | 7,419,425.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,563,500.00 | 14,252,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,222,500.00 | 5,679,500.00 |
| 210602 | Тавилга | 1,231,000.00 | 539,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,110,000.00 | 8,033,050.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 92,000.00 | 435,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 92,000.00 | 435,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,960,550.00 | 7,349,408.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,960,550.00 | 7,349,408.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 785,750.00 | 244,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 785,750.00 | 244,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,558,313.18** | **2,322,139.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,499,350.00 | 2,322,139.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,499,350.00 | 2,322,139.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,058,963.18 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,058,963.18 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **75,082,626.27** | **174,536,863.44** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **36,458,500.00** | **48,657,990.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **36,458,500.00** | **48,657,990.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 36,458,500.00 | 48,657,990.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 36,458,500.00 | 48,657,990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(36,458,500.00)** | **(48,657,990.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 38,624,126.27 | 125,878,873.44 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 38,624,126.27 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 38,624,126.27 | 164,502,999.71 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 285,892,103.87 | 155,744,564.19 | (88,829,667.64) | | 352,807,000.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **285,892,103.87** | **155,744,564.19** | **(88,829,667.64)** | - | 352,807,000.42 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 219,848,804.35 | | 219,848,804.35 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **285,892,103.87** | **155,744,564.19** | **131,019,136.71** | - | 572,655,804.77 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **285,892,103.87** | **155,744,564.19** | **131,019,136.71** | - | 572,655,804.77 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **285,892,103.87** | **155,744,564.19** | **131,019,136.71** | - | 572,655,804.77 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 88,668,424.28 | | 88,668,424.28 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **285,892,103.87** | **155,744,564.19** | **219,687,560.99** | - | 661,324,229.05 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 668462300.00 | 462669358.46 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 668462300.00 | 462669358.46 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 664162300.00 | 460347219.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 381192000.00 | 285170103.57 |
| 210101 | Үндсэн цалин | 274839700.00 | 194747797.73 |
| 210102 | Нэмэгдэл | 90141200.00 | 64513362.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6197000.00 | 3543000.00 |
| 210104 | Урамшуулал | 10014100.00 | 22365943.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47648900.00 | 38361260.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32401300.00 | 26882273.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3811900.00 | 2869746.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3049500.00 | 2295797.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 762400.00 | 573950.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7623800.00 | 5739493.52 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19724800.00 | 18898761.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4000000.00 | 3407774.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14124800.00 | 14511737.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1600000.00 | 979250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39323000.00 | 31487927.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4974900.00 | 4559182.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17379000.00 | 11933100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,520,100.00 | 1,648,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 14,449,000.00 | 12,899,645.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 448,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,762,400.00 | 64,147,808.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,777,500.00 | 55,928,383.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,735,000.00 | 7,419,425.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,249,900.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 86,256,300.00 | 14,252,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,248,900.00 | 5,679,500.00 |
| 210602 | Тавилга | 9,007,400.00 | 539,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,000,000.00 | 8,033,050.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,099,900.00 | 435,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,099,900.00 | 435,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,154,900.00 | 7,349,408.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,859,900.00 | 7,349,408.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,295,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,000,100.00 | 244,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,100.00 | 244,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,300,000.00 | 2,322,139.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,300,000.00 | 2,322,139.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,300,000.00 | 2,322,139.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 668,462,300.00 | 637,206,221.90 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,019,800.00 | 25,810,761.90 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,019,800.00 | 25,810,761.90 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 638,442,500.00 | 611,395,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 638,442,500.00 | 611,395,460.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **12,215,705.39** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **164,502,999.71** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Халзан сумын Эрүүл мэндийн төв нь "Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг хэнийг ч орхигдуулахгүй түргэн шуурхай, цаг алдалгүй үзүүлэх зорилготой ажиллаж байна. Байгууллагын хувьд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээ, гэрийн тусламж үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ, түргэн тусламж, яаралтай тусламжийн үйлчилгээ" гэсэн ажил үүргийн хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, ард иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлдэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ,төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам"
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугээр тогтоол "Багц,төлбөрийн хэмжээ,журам батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,667.4 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 38,624.1 | 164,502.9 | 125,878.8 |
| Авлага | 117,736.0 | - | -117,736.0 |
| Бараа материал | 60.741.5 | 99.975.1 | 39,233.6 |
| Үндсэн хөрөнгө | 361,940.8 | 403,232.7 | 41,291.9 |
| Нийт хөрөнгө | 579,042.5 | 667,710.9 | 88,667.4 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 579,042.5 | 667,710.9 | 88,667.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 579,042.5 | 667,710.9 | 88,667.4эц |
| | | | |

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 54,582.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- *Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 125,878.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ.*
- *Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 99,975.2 мянган төгрөг болж 39,233.6 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 12,908.5 мянга, бусад хангамжийн материал 2,999.1 мянга, тусгай зориулалтын материал 34,710.2 мянга, Бичиг хэргийн материал 549.9 мянга, сэлбэг хэрэгсэл 7.5 мянга, Түлш халаалт тослох материал 1,413.3 мянга, нийт 57,111.8 мянган төгрөгөөр үлдэгдэл өссөн, мал амьтад 410.0 мянга, Аж ахуйн материал 658.3 мянга, барилга засварын материал 11,469.4 мянга, хүнсний материал 817.3 мянган, нийт 12,696.7 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна*
- *Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 403,232.7 мянга, 88,667.4 мянгаар өссөн нь Сумын уяачдын холбооноос анхан шатны тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор 20,000.0 мянган төгрөгийн прүсс-20 авто машин хандивласан. Бусад эх үүсвэрээс зөөврийн компьютер 2,275.0 мянга, хүчил төрөгч өтгөрүүлэгч 1,317.7 мянга, Төсвийн хөрөнгөөр нэн шаардлагатай машин тоног төхөөрөмж 11,963.0 мянга, тавилга эд хогшил 34,699.9 мянга, программ хангамж 1,995.0 мянга нийт 48,657.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан. Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны 448 тоот албан бичгээр 21 нэр төрлийн 11,028.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассанаар буурсан байна.*
- *Авлагын дансны үлдэгдэл 117,736.0 мянган төгрөг буурсан нь Эрүүл мэндийн сайдын А/337-99 тоот тушаалын дагуу ковид-19 цар тахлаар өвчлөн хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөр эрүүл мэндийн даатгалаас оны эхэнд олгогдсон байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлтөөр ЭМДС-аас санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан 638,442.5 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 638,442.5 мянга, орон нутгийн санхүүжилт 30,019.8 мянга нийт 668,462.3 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 637,206.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 611,395.4 мянга, орон нутгийн санхүүжилт 25,810.7 мянга, нийт 637,206.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 164,502.9 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 511,327.1 мянган төгрөг буюу 76.5 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | *80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал* | 21,642,2 | 21,642.2 | 0 | 100% |
| **2** | *80302-Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон* | 181,863.3 | 149,847.6 | 32,015.7 | 82.4% |
| **3** | *81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ* | 324,668.2 | 343,811.8 | -19,143.6 | 105.9% |
| **4** | *83201-Ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ* | 4,495.0 | 4,495.0 | 0 | 100% |
| **5** | *83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хувиарласан* | 131,796.0 | 117,736. | 14.060,0 | 89.33% |
| ***НИЙТ*** | | 642822.5 | 615890.0 | 12872.0 | |

*Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон зардлаас санхүүжих 32,015.7 мянган төгрөгөөр дутуу, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжих 19,143.5 мянган төгрөг илүү санхүүжсэн байна. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцэж, эмчилгээ үйлчилгээг стандартын дагуу хийсэнтэй холбоотой байна.*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 593,003.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,895.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2], 15.2.4-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад түлш халаалт зардал 5,345.9 мянга, гэрэл цахилгаан зардал 173.9 мянга, цэвэр бохир ус 800.0 мянга, бичиг хэргийн зардал, төгрөгөөр буурсан байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Түлш халаалтын зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8[3] заасныг зөрчиж байна.

---

[1] *байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;*
[2] *сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;*

[3] *бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;*

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төв нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг гүйцэтгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 12,398.2 | 2 | 12,398.2 | 100 |
| Албан шаардлага | 4 | 69,509.8 | 4 | 69,509.8 | 100 |
| Зөвлөмж | 3 | - | 2 | - | 66.6 |
| Нийт дүн | 9 | 81,908.0 | 8 | 81,908.0 | 88.8 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 5,190.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчил дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 5,190.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4[4] дэх заалтыг зөрчсөнд албан шаардлага өгөв.

5.1.2 Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8[5] заасныг зөрчсөнд албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

[4] *Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*
[5] *бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*

| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 9,880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна. | 1 | 5,190.0 | | | 1 | 5,190.0 | | | | | | |
| **Дүн** | 1 | 5,190.0 | | | 1 | 5,190.0 | | | | | | |

| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |